



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 25 -ны өдөр

Дугаар А/151

Эрдэнэт

Хандив тусламжаар ирсэн эм, эмнэлгийн хэрэгслийг хуваарилах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9.1.4 дахь заалт, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13.1.2 дахь заалт, Иргэний хуулийн 276.6 дахь заалт, 2020 оны 02 сарын 05 өдрийн Улсын онцгой комиссын 3-р хурлын тэмдэглэлийн 1.2, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 сарын 22 өдрийн 19-р албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Covid-19 халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал хангахад зориулж Орхон аймгийн Эм холбооноос хандивласан эм, эмнэлгийн хэрэгслийг эрүүл мэндийн байгууллагуудад өгөх хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн байгууллагуудад олгох хуваарь гаргаж, зарцуулалтын тайланд хяналт тавихыг Эмийн бодлогын хэрэгжилт, чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн /О.Анхбаяр/-т үүрэг болгосугай.

3. Хуваарийн дагуу Эрүүл мэндийн байгууллагуудад олгох, баримтжуулахыг нярав /Л.Даваажав/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ХШҮДАХ мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ

My doc. EMG-iin dargiin tushaal

COVID-19 цар тахлын үед ажилласан эмч, сувилагч, үйлчлэгч нарт олгох амин

д/д	Байршил	Нэр, төрөл	Ажилчдын тоо	хэмжих нэгж	Тоо ширхэг	нэг бүрийн үнэ	Нийт
1	Тусгаарлалтын байр болон ажиглалтын байрнуудад ажилласан эмч, сувилагч, үйлчлэгч нарт	Маск	25	ш	250	500	125,000
		Витагрипп		уп	16	9000	144,000
		Салимон		фл	17	3500	59,500
		Витамин D3 актив 1000 тун		уп	1.2	20,000	24,000
		Вакус		ш	25	800	20,000
		Витамин D3 жунеор 500 тун		уп	1.25	15,000	18,750
2	Шуурхай арга хэмжээний I, II, III багт	Маск	22	ш	430	500	215,000
		Витагрипп		уп	30	9000	270,000
		Салимон		фл	32	3500	112,000
		Витамин D3 актив 1000 тун		уп	2.4	20000	48,000
		Вакус		ш	43	800	34,400
		Витамин D3 жунеор 500 тун		уп	2.5	15000	37,500
3	Булган, Жаргалантын постонд ажилласан эмч нарт	Маск	38	ш	300	500	150,000
		Витагрипп		уп	17	9000	153,000
		Салимон		фл	38	3500	133,000
		Витамин D3 актив 1000 тун		уп	2.4	20000	48,000
		Вакус		ш	76	800	60,800
		Витамин D3 жунеор 500 тун		уп	1.25	15000	18,750
4	ЭМГ албан хаагчдад	Маск	32	ш	20	500	10,000
		Витагрипп		уп	1	9000	9,000
		Вакус		ш	26	800	20,800
Нийт							1,711,500

Хуваарь гаргасан: ЭБХЧАБЗХХМэргэжилтэн
 Хянасан: Эдийн засагч

О.Анхбаяр
 Д.Отгондэлгэр